

2006 оны 1–р сарын 12
Улаанбаатар хот
Удирдлагын Академи дээр
Элчин сайд Памела Слуцын хэлсэн үг

Америк–Монголын харилцаа:
Иж бүрэн түншлэлийн шинэ эрин үе

Ноёд, хатагтай нараа!

Улаанбаатарт суугаа элчин сайдын хувьд Америк–Монголын харилцааны сүүлийн үеийн байдлын тухай ярихаар Удирдлагын Академийн урилгаар өнөөдөр энд хүрэлцэн ирсэндээ би баяртай байна. Би илтгэлээ "Америк – Монголын харилцаа: Иж бүрэн түншлэлийн шинэ эрин үе" гэж нэрлэсэн юм. Энэ нэр манай хоёр орон болон ард түмнүүдийн харилцаа улам өргөжин гүнзгийрч буйг илэрхийлж байгаа гэдэгт би итгэж байна. Энэ цаг үе бол Ерөнхийлөгч Буш болон Америкийн ард түмнийг Монгол улсад төлөөлж суухад үнэхээрийн сонирхолтой цаг үе юм.

Хоёр талын харилцааны гол асуудлууд

1–р сарын 27–нд АНУ, Монгол Улстай дипломат харилцаа тогтоосны 19 жилийн ойг бид тэмдэглэнэ. Дипломат харилцаа тогтоосноос хойшхи энэ 19 жилийн дотор Америк– Монголын харилцаа улам бүр өргөжин гүнзгийрсээр байна. 1990 оноос хойш Монгол улс захиргаадалтын коммунист засаглалаас ардчилсан засаглал, чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжих 15 жил үргэлжилж буй тайван бөгөөд бүх салбарт нэгэн зэрэг явагдсан шилжилтийн үйл явц нь Ази тивийн амжилтын түүхэнд зүй ёсоор бичигддэг. Үнэндээ Монголын ард түмэн асар их амжилт олсон бөгөөд өнөөг хүртэл олсон амжилтаараа бахархах ёстой юм.

Өнөөдөр Монгол Улс бол АНУ–д үнэлэгддэг найз нөхөр нь бөгөөд түнш нь юм. "Монгол Улс ардчилсан, хараат бус, аюулгүй байдлаа бүрэн хангасан, цэцэглэн хөгжиж буй улс байх нь АНУ–ын үндэсний ашиг сонирхолд нийцэж байгаа юм". Монгол Улс хөрш орнуудтайгаа найрсаг харилцаа хөгжүүлж, бүс нутгийн болон олон улсын эдийн засаг, улс төр, аюулгүй байдлын чуулга уулзалтуудад идэвхтэй оролцож байх нь АНУ болоод Азийн бүс нутгийн ашиг

сонирхолд бүхэлдээ нийцэж байгаа юм. Терроризмын эсрэг дэлхий нийтийн тэмцэл болоод Ази, ялангуяа Зүүн Хойд Азийн энх тайван, тогтвортой байдлыг хангахад Монгол улс дэмжлэг үзүүлсээр байна.

2004 оны 7-р сарын 15-нд манай хоёр орны ерөнхийлөгч нар Вашингтонд уулзах үеэрээ хамтарсан мэдэгдэл хийсэн бөгөөд энэ мэдэгдэлдээ "ардчилсан хоёр орны хооронд хамтын үнэт зүйлс болон стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан хамтын ажиллагаа, иж бүрэн түншлэлийн шинэ эрин үеийг зарлан тунхагласан" билээ.

<http://www.whitehouse.gov/news/releases/2004/07/20040715-13.html>

сайтыг үзнэ үү.

2005 оны 11-р сарын 21-нд манай хоёр ерөнхийлөгч Улаанбаатар хотноо уулзахдаа мөн Хамтарсан мэдэгдэл хийсэн. Энэ мэдэгдэлдээ: " АНУ, Монгол Улсын уламжлалт харилцааг дахин баталж, хоёр орны иж бүрэн түншлэлийн удирдах зарчмуудыг тодорхойлж, цар хүрээг нь өргөтгөхөөр тохиролцсон" билээ. <http://www.whitehouse.gov/news/releases/2005/11/20051121-1.html> сайтыг үзнэ үү.

"Иж бүрэн түншлэл", "хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашиг", "удирдах зарчмууд", "цар хүрээг өргөтгөх" гэдгээр бид юуг илэрхийлж байна вэ? Эдгээр асуудлуудыг би энд өнөөдөр ярья гэж бодож байна.

Иж бүрэн түншлэлийн харилцаа

"Иж бүрэн түншлэл" гэдгийг АНУ яаж ойлгож байгаа тухайгаас би яриагаа эхлэе. АНУ бусад зарим орнууд шиг гадаад улс орнуудтай тогтоосон харилцаандаа янз бүрийн нэр өгдөггүй. Харин АНУ-тай "холбоотны гэрээ" буюу албан ёсны, харилцан батлан хамгаалах гэрээ байгуулсан улс орнууд бол өөр хэрэг. Ази, Номхон Далайн бүс нутагт АНУ нь БНСУ, Япон, Филиппин, Тайланд, Австрали гэсэн албан ёсны 5 ийм холбоотонтой. Эдгээр улсууд болон манай улстай ийм гэрээ байгуулсан дэлхийн бусад улс орнууд манай "стратегийн түншүүд буюу холбоотнууд" гэж нэрлэгдэх боломжтой.

Дээр хэлсэнчлэн АНУ нь Монгол Улсыг "үнэлэгдсэн анд нөхөр, түнш" гэж үзсээр ирсэн. 2004 оны Хамтарсан мэдэгдэлд "иж бүрэн" гэдэг үгийг Монголын талын саналаар нэмж оруулсан юм. Монгол

Улс бусад орнуудтай тогтоосон харилцаандаа нэр өгдөг бөгөөд эдгээр харилцааны эрэмбэ дараалалд нилээд чухал ач холбогдол өгдөг гэж би ойлгодог. "Иж бүрэн түншлэл" гэдэг нэр томъёог Монгол Улс өөрийн "Гуравдахь хөршүүд" буюу Япон, Герман, Турк, одоо АНУ–тай тогтоосон харилцаагаа томъёолохдоо ашигладаг.

Харин 2004 оны Хамтарсан мэдэгдэлд АНУ, Монгол Улс хоёр "стратегийн нийтлэг эрх ашигтай" гэж тэмдэглэсэн. АНУ–ын үзэж байгаагаар Солонгосын хойгийг цөмийн зэвсгээс ангид байлгах асуудлаас эхлээд Зүүн хойд Азийн энх тайван, тогтвортой байдлын асуудалд бид Монгол Улстай "стратегийн нийтлэг эрх ашиг"–тай юм. Зургаан тал хэлэлцээрийн зорилтууд, ялангуяа 2005 оны 9 сарын Хамтарсан мэдэгдлийг дэмжиж байгаад нь бид Монгол Улсад талархаж байна.

Тэгэхээр, АНУ–ын үзэж байгаагаар "иж бүрэн түншлэлийн харилцаа" гэдэг нь хоёр талын, бүсийн болон дэлхийн түвшинд, маш олон янзын асуудлаарх бидний хамтын ажиллагаа хэр гүнзгий болоод өргөн хүрээтэй болохыг илэрхийлж байгаа юм.

Бүсийн болон олон улсын түвшин дэх хамтын ажиллагаа

2004 оны 7–р сарын Хамтарсан мэдэгдэлд тэмдэглэснээр АНУ нь "бүс нутгийн болоод олон улсын эдийн засаг, санхүүгийн бүтцүүдэд нэгдэн орох талаарх Монгол Улсын хүчин чармайлтыг тууштай дэмждэг". Эдгээр байгууллагуудад Монгол Улс нэгдэн орохыг дэмжихийн зэрэгцээ бид бүс нутгийн болон олон улсын түвшний гол гол асуудлаар Монгол Улстай хамтран ажиллах арга замуудыг хайж байдаг.

Энэ нь манай хоёр орны хувьд нийтлэг байдаг асуудлуудаар олон улсын болон бүс нутгийн чуулга уулзалтууд дээр хамтран ажиллах явдал юм. Жишээлбэл, НҮБ, бусад байгууллагуудад терроризмын аюул заналын эсрэг болон олон улсын энхийг санхиулах асуудлаар, Дэлхийн худалдааны байгууллагад Дохагийн дугуй ширээний хэлэлцээрийн зорилтуудыг хэрэгжүүлэх асуудлаар, Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгт дэлхий даяар ардчилал, эрх чөлөөг дэлгэрүүлэх асуудлаар, итгэлийг бэхжүүлэх, АСЕАН–ны бүс нутгийн чуулга уулзалтад дипломат аргаар урьдчилан сэргийлэхийг дэмжих асуудлаар, Ази, Номхон далайн Группт

мөнгө угаахтай тэмцэх асуудлаар , Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны нийгэмлэг, шинээр байгуулагдсан Олон улсын түншлэлд шувууны болон гоц халдварт ханиадны тархалтаас сэргийлэх асуудлаар хамтран ажиллаж байна. Эдгээр нь бидний хамтын ажиллагааны цөөн хэдэн жишээ юм.

Олон улсын энхийг сахиулах асуудлаарх бидний хамтын ажиллагааг онцлон тэмдэглэхийг хүсч байна. 1999 онд Монгол Улсын Засгийн газраас тавьсан хүсэлтийн дагуу 2005 он гэхэд олон улсын энхийг сахиулах ажиллагаанд оролцох бэлтгэлийг хангах зорилготойгоор Монгол цэргийн боловсон хүчнийг сургах 5 жилийн хөтөлбөрийг АНУ санаачилсан юм. Монгол Улс энэ хөтөлбөрийн хурдцыг улам нэмэгдүүлж, мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн энхийг сахиулагчдыг 2003 онд Ирак руу илгээж чадсан. 2005 оны эцсээр Монгол Улс Сиерра Леон руу энхийг сахиулагчдаа явуулсан нь НҮБ-ын мандаттай Энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улс анх удаагаа оролцож буй бөгөөд Монголын энхийг сахиулагчдын гадаад орнуудаас хүлээж буй өндөр хүндэтгэлийн илрэл болж байна.

Энхийг сахиулах асуудлаар Монгол улс тууштай байгааг үнэлж АНУ 2005 онд 15 сая орчим ам.долларын нэмэлт санхүүжилтийг баталж, Улаанбаатараас холгүй орших Таван толгойн сургалтын төвийг энхийг сахиулагчдыг бэлтгэх бүсийн сургалтын төв болгох, хамтарсан дасгал, сургуулилт хийх замаар энхийг сахиулах чадавхиа нэмэгдүүлэхэд нь Монгол Улсад туслах болсон юм.

2005 оны 11-р сарын Хамтарсан мэдэгдлээр хүлээсэн үүргийнхээ дагуу цаашид бид бүс нутгийн болон олон улсын түвшинд хамтын ажиллагааныхаа цар хүрээг "өргөжүүлнэ" гэдэгтэй итгэлтэй байна. Тухайлбал, АПЕК буюу Ази, Номхон далайн орнуудын Эдийн засаг, хамтын ажиллагааны байгууллага, НҮБ болон бусад байгууллагуудад хүн наймаалах гэмт хэрэг, авилгал, мансууруулах бодис, түүнийг зөөвөрлөх, зохион байгуулалттай гэмт хэрэг, үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэх болон мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх асуудлаар бид хамтран ажиллах болно.

Хоёр талын хамтын ажиллагаа

Би сая бүс нутгийн болон олон улсын түвшин дэх манай хоёр улын хамтын ажиллагааны тухай ярилаа. Мэдээж манай хоёр улсын хамтын ажиллагаа, ажил хэргийн ихэнх нь хоёр талын шинжтэй байдаг. 2004 оны Хамтарсан мэдэгдэлд тэмдэглэсэнээр "Монгол Улсад хийгдэж байгаа ардчилсан шилжилт, эдийн засгийн шинэчлэлийг АНУ тууштай дэмжиж байгааг Ерөнхийлөгч Буш илэрхийлээд, хувийн хэвшил зонхилсон чөлөөт зах зээлийн эдийн засгийг бэхжүүлж, боловсронгуй, тогтвортой ардчиллыг төлөвшүүлэн хөгжүүлэх үйлстээ ахиц дэвшил гаргаж байгаад баяр хүргэсэн" юм. Монголын ард түмэн, Засгийн газрын хүсэлтээр Энх тайвны корпус, АНУ-ын ОУХА 1991 оноос Монголд ажиллаж эхэлсэн бөгөөд авторитар дэглэмээс ардчилсан нийгэмд, төрийн өмчит, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас хувийн хэвшил зонхилсон эдийн засаг, хөгжил цэцэглэлтэнд хүрэх Монголын шилжилтийг Америкийн ард түмэн болон хэд хэдэн Засаг захиргаа нь (БН-чууд ч, Ардчилсан намынх нь ч) дэмжсээр ирсэн.

Эдийн засаг, улс төрийн шинэчлэлийг зэрэгцүүлэн хийж, ижил төстэй замаар замнаж буй Төв болон Зүүн Азийн бусад орнуудын хувьд өнөөдөр Монгол Улс үлгэр дууриал болох нь элбэг. Ерөнхийлөгч Буш хэлсэн үгэндээ: " Бүс нутагтаа болон дэлхий дахинд танай орон амжилтын үлгэр дууриал болж байна. Эрх чөлөөгөө олох нь ямагт амаргүй байдгийг би мэдэх бөгөөд та бүхний тэвчээр зоригийг америкчууд бахархдаг юм" гэж Монгол Улсыг өндрөөр үнэлсэн билээ. Монгол Улс ардчилсан засаглалд шилжиж, хувийн хэвшил зонхилсон эдийн засгийн өсөлтөнд хүрэх явц хараахан дуусаагүй байгааг та бид бүгд мэдэж байгаа. АНУ болон бусад орнуудын түүхэн туршлагаас харахад энэ нь удаан үргэлжилдэг, олон үе шат дамждаг үйл явц бөгөөд дандаа тийм өө сэвгүй, эсвэл адилхан байдаггүй.

Бидний зорилго бол энэхүү шилжилтийг аль болохоор зөв бөгөөд аядуу замаар цааш нь үргэлжлүүлж, Монгол улсыг тогтвортой хөгжил, урт хугацааны эдийн засгийн өсөлт, цэцэглэлтэнд хүргэхүйц институцууд, хууль журам, арга механизмууд, зан төлөвийн стандартуудыг бий болгоход туслахад оршино. Энэ туслалцаа нь хөгжлийн тусламж хийгээд худалдаа, хөрөнгө оруулалтын хэлбэрээр ирж байгаа юм.

1991 оноос хойш голчлон АНУ–ын ОУХА–аар төдийгүй бусад олон агентлаг, хөтөлбөрүүдээр дамжуулан АНУ Монголд 150 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлжээ. Энэ тусламжийн нилээд хэсгийг 1990–ээд оны эхээр Оросууд тусламжаа зогсоосны дараа Улаанбаатар хотын 3, 4–р цахилгаан станцуудын хэвийн үйл ажиллагааг үргэлжлүүлэхийн тулд өгсөн юм.

Одоо 2004–2008 онд АНУ–ын ОУХА–аас Монголд хэрэгжүүлэх 5 жилийн стратеги төлөвлөгөө нь

- Бизнесийн хөгжлийн сургалт явуулах, жижиг аж ахуйн нэгжүүдэд банкнаас зээл авахад нь туслах замаар хөдөө орон нутаг, хотын захын хорооллын ядуу иргэдэд ажлын байр, орлого бий болгох
- Макро эдийн засгийн бодлогын талаар зөвлөх (татварын шинэтгэл, хувьчлал, худалдааны бодлого)
- Парламентын болон сонгуулийн, шүүх эрх мэдлийн шинэчлэл хийх болон
- Авилгалтай тэмцэхэд

голчлон чиглэгдэж байна.

Манай Олон нийттэй харилцах хэлтэс бага хэмжээний буцалтгүй тусламж, оюутан солилцоо, цөөн тооны тэтгэлэгт хөтөлбөрүүдээр дамжуулан боловсрол, соёлыг дэмждэг. Мөн иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хөгжлийг дэмжих бага хэмжээний буцалтгүй тусламж үзүүлдэг. Монголд хийсэн айлчлалынхаа дараа, Монголын төр засгийн удирдлагуудаас тавьсан хүсэлтийг харгалзан Ерөнхийлөгч Буш Фулбрайт болон АНУ–ын Засгийн газраас санхүүжигддэг тэтгэлэгт хөтөлбөрүүдийнхээ тоог хоёр дахин нэмэгдүүлэх бодолтой байна.

Одоо Монгол Улсад Энх тайвны корпусын 100 гаруй сайн дурын мэргэжилтнүүд голчлон хөдөө орон нутагт Англи хэлний багшаар ажиллаж байгаа бөгөөд зарим нь эрүүл мэнд, залуучуудын хөгжлийн чиглэлээр ч ажиллаж байна. 1991 оноос хойш Монголд 500 гаруй сайн дурын мэргэжилтгүүд ажилласан бөгөөд тэд АНУ–д

буцаж очоод Монголын төлөө "сайн санааны элч" нарын томоохон хүчийг бүрдүүлдэг юм.

Цаашид манай талаас үзүүлэх хөгжлийн тусламж Мянганы Сорилын Сангаар дамжин үлэмж хэмжээгээр нэмэгдэх төлөвтэй байна. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын олсон ололт амжилтыг үнэлж, мөн цаашид ардчилал, чөлөөт зах зээлд шилжих шилжилтээ үргэлжлүүлэх урам зориг өгөх зорилгоор анх 2004 онд МСС–аас тусламж авахаар өрсөлдөх орнуудын тоонд Монгол Улсыг багтаасан юм. МСС нь улс орнуудыг хийсэн бүтээснийх нь төлөө урамшуулж, бодлогын эрчимтэй шинэчлэл хийх урам зоригийг өгдөг эдийн засгийн тогтвортой өсөлтөд хүрэх шинэ хандлага юм. МСС болон Монгол Улсын өргөн барьсан саналын талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл www.mca.gov , www.mca.mn сайтуудыг үзнэ үү)

МСС–аас тусламж хүртэх эрхийг олж авах үйл явц нь нилээд сонирхолтой бөгөөд санхүүжилт авахын тулд Монгол Улс жил бүр шалгуурыг хангасан хэвээр байх ёстой учраас миний бодлоор зарим тайлбарыг зөвтгөдөг. Орлого багатай, шилжилтийн шатандаа яваа ижил түвшний бусад орнуудтай харьцуулахад Монгол Улс хаана нь явж байна вэ гэдэг дүр зургийг гаргадаг учир энэ үйл явц нь бүхэлдээ их сургамжтай юм. Мөн надаас байн байн хүмүүс асуудаг, "Монгол Улс хэр зэрэг ардчилсан улс вэ?" гэсэн асуултанд хариулахад нэмэр болох юм. Мянганы Сорилын Корпорац нь МСС–аас тусламж авах эрхтэй орнуудыг жил тутам шинэчлэн тогтоодог болохоор Монгол Улс жил бүр шалгуурыг хангах ёстой. Үүний тулд Монгол Улс (нэг хүнд ноогдох орлогын түвшнээрээ ижил бусад орнуудтай харьцуулахад) хууль ёсыг дээдлэх (ардчилал, хүний эрх), эдийн засгийн эрх чөлөөг дэмжих, хүмүүсийнхээ эрүүл мэнд, боловсролд хөрөнгө оруулалт хийх талаар хэрхэн ажиллаж байгааг хэмжих 16 шалгуурыг давсан байх ёстой.

МСС нь шалгууруудаа тогтоохдоо хүний эрх, эрх чөлөө, авилгал, эдийн засаг, нийгмийн бодлогод ажиглалт хийдэг олон улсын нэр хүнд бүхий байгууллагуудын хийсэн судалгааны дүн дээр тулгуурладаг. Гадаад бодлогын ямар нэг "шалгуур" байдаггүй бөгөөд жишээ нь Монгол Улс Иракт энхийг сахиулагчдаа явуулсан зэргийг харгалзаж үздэггүй юм. Энэ шалгуурууд нь маш бодитой хэмжүүр байхаар хийгддэг бөгөөд хэммждэг аргачлал нь ил тод

байдаг. Оноог тогтооход ашигладаг аргачлал, шалгуур, сорилуудыг www.mca.gov сайтаас харж болно. (Хувийг хавсаргав) МСС–ийн ашигладаг тэрхүү судалгааны дүнгээр авсан оноогоороо Монгол Улс 2004, 2005, 2006 онд МСС–аас санхүүжилт авах эрхтэй болсон нь маш сайн хэрэг. 2004 онд 63 орныг авч үзсэнээс 16, 2005 онд 78–аас 16, 2006 онд 91–ээс 23 орон сонгогдсоны тоонд Монгол Улс багтсан билээ. Дараачийн шалгаруулалтыг 2006 оны 10–р сард хийж, шийдвэрийг гаргана

Өнгөрсөн хугацаанд олсон амжилт, шалгаруулалтанд тэнцсээр байгаа зэрэг нь Монгол Улсын хувьд мэдээж сайшаах зүйл мөн ч сүүлийн 3 жилийн хугацаанд оноо нь буурч байгаа, анхаарал тавьж, арга хэмжээ авах шаардлагатай байгаа зарим үзүүлэлтүүд байна. Энэ нь авилгалд тавих хяналт, төр засгийн үр нөлөөтэй байх байдал, инфляцийн хяналт, төсвийн алдагдлал зэрэг асуудлууд юм. Ялангуяа авилгалтай тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар ахиц гарахгүй бол "авилгалын хяналт" гэдэг үзүүлэлтээр МСС–аас санхүүжилт авах эрхгүй болох хүртэл хэмжээнд Монголын оноо бүр доошилж магадгүй. Хэрэв Монгол Улсыг (Йемен шиг) санхүүжилт авах эрхгүй гэж зарлах юм бол МСС–ийн санхүүжилт зогсоход хүрнэ. Гэрээ хийгдсэн байлаа ч Монголыг эрхээ дахин сэргээхээс нааш санхүүжилтийг хийхгүй.

Худалдаа, хөрөнгө оруулалт

Хөгжлийн тусламж авч буй ямар ч орны эцсийн зорилго бол тогтвортой өсөлтөд хүрч, хүн амын орлого нэмэгдсэнээр гадны тусламж авах ямар ч шаардлагагүй болох, өөрөөр хэлбэл зээл тусламжаас хамааралгүй байж чадах тийм байдалд хүрэх явдал байдаг. Жишээлбэл, танайхтай ойрхон байгаа Өмнөд Солонгос, Тайван, Тайланд зэрэг орнууд ийм болж чадсан. Ер нь худалдаа наймаа болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр эдийн засгийн өсөлт хурдасдагийг туршлага харуулдаг.

Худалдааны чиг баримжаа. Монголын талын тооцоолсноор, сүүлийн хэдэн жилд АНУ нь Монголын хоёр дахь том худалдааны түнш бөгөөд зах зээл нь болж чаджээ. Монголоос АНУ руу экспортолдог барааны ихэнх хэсгийг оёмол, сүлжмэл бүтээгдхүүн эзэлж байсан. 2004 оны эцсээр оёмол, сүлжмэл бүтээгдхүүний квот дуусгавар болсноор илүү өрсөлдөөн бүхий зах зээлийн шинэ

нөхцөлд Монгол Улсаас энэ төрлийн бүтээгдхүүнийг экспортлох асуудал нилээд хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. Гарсан үр дагавар нь нилээд ноцтой харагдаж байна. 2005 оны эхний 10 сарын байдлаар оёмол, сүлжмэл бүтээгдхүүний гарц өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 26%-иар буурчээ. 2004 оны нийт худалдааны эргэлтийн (72.4 сая ам.доллар) 19.1 хувийг Монголоос АНУ руу гаргасан экспортын бараа бүтээгдхүүн эзэлж байсан бол энэ тоо 2005 онд 9.1 хувь (43.5 сая ам.доллар) болтлоо буурсан байна. Үүний дотор оёмол, сүлжмэл эдлэлийн экспорт 15.9 хувиас (60.2 сая ам.доллар) 6.7хувь (32.1 сая ам.доллар) болж буурчээ.

2005 оны 5 сард АНУ–ын Худалдааны Яам Америкийн хөнгөн үйлдвэрийн салбарыг Хятадын өрсөлдөөнөөс хамгаалахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авахаа мэдэгдсэн. Энэхүү хамгаалах механизмуудын хүрээнд Хятадад үйлдвэрлэсэн тодорхой төрлийн бэлэн хувцас буюу хөвөн даавуун цамц, өмд, дотуур хувцасны импортыг хязгаарлах болсон.

(http://www.commerce.gov/opa/press/Secretary_Gutierrez/2005_Releases/May/19_CITA.htm) Үүний үр дүнд Хятадын компаниуд үйлдвэрүүдээ энэхүү хязгаарлалтанд өртөөгүй улсууд, түүний дотор эргээд Монгол руу шилжүүлж байна. Тэгэхээр, гадаад худалдааны энэхүү нөхцөл байдал квотын төгсгөл болсноос үүдэн Монголын оёмол бүтээгдхүүний салбарт тулгараад байсан бэрхшээлийг түр боловч намжааж болох юм.

Гэхдээ АНУ–ын энэ арга хэмжээ болоод Монголын оёмол, сүлжмэл бүтээгдхүүний экспортын энэхүү амсхийлт зөвхөн түр хугацааных юм. Хятад улс ДХБ–д элсэх нөхцлийн хүрээнд энэхүү хамгаалалтын механизмыг цаад тал нь 2008 он хүртэл л хэрэглэх боломжтой шилжилтийн механизм юм. Монгол зэрэг орны жижиг үйлдвэрлэгчид үүссэн энэхүү нөхцөл байдлыг ашиглан энэ төрлийн үйлдвэрлэлийнхээ уналтыг зөөлрүүлэх, үйлдвэр, ажиллах хүчийг өөр зорилгод нийцүүлэн өөрчлөн зохион байгуулах арга хэмжээ авах шаардлагатай.

Эдийн засгийн өсөлтөнд худалдаа нэн чухал үүрэг гүйцэтгэж болохыг бүрнээ ойлгож АНУ Монгол Улстай Худалдаа хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр (ХХОЕХ) байгуулах санаачлага гаргаж, 2004 оны 7 сард гарын үсэг зурсан. ХХОЕХ–ийн анхны жилийн хуралдаан 2005 оны 1 сард Улаанбаатар хотод болсон, 2

дахь удаагийн жилийн хуралдаан энэ оны 3-р сард Вашингтон хотод болно.

Худалдаа хөрөнгө оруулалтын ерөнхий хэлэлцээр гэдэг нь АНУ-ын бусад оронтой хийх худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэхэд баримталдаг зөвлөх механизм юм. Энэ хэлэлцээрийн дагуу ямар нэг үүрэг хүлээхгүй ч худалдааны онцлог асуудлуудыг шийдвэрлэж, худалдааны түншүүддээ туршлага хуримтлуулах, институциуд болон хууль тогтоомжийг бий болгож, дэлхийн эдийн засагт нэгдэн ороход нь туслах зэргээр шууд үр дүнг нь үзэх боломжтой.

АНУ-тай Чөлөөт худалдааны гэрээ (ЧХГ) байгуулах асуудлыг Монголын талаас тавьж байгаа. АНУ Монгол Улстай ЧХГ байгуулах боломжийг үндсэнд нь үгүйсгээгүй ч үүний өмнө хийгдэх ёстой бэлтгэл ажил маш их байгаа нь үүнийг хийж дуусгахад нилээд хэдэн жил ч шаардагдаж болзошгүй юм. Тиймээс 3 сард болох ХХОЕХ-ийн хуралдаан дээр ЧХГ байгуулах асуудлыг хэрхэн урагшлуулах талаар төлөвлөгөөгөө ярилцах байх гэж найдаж байна.

Хөрөнгө оруулалтын чиг баримжаа. АНУ-аас Монголд оруулсан хөрөнгө оруулалт 2003 онд 115 сая ам.доллар байсан бол 2004 онд 135.4 сая болж нэмэгдэн Монголд хийгдсэн нийт хөрөнгө оруулалтын 10.5 хувийг эзэлж, АНУ нь Хятад, Канадын дараа гуравдахь том хөрөнгө оруулагч болсон байна. Харин хамгийн сүүлд Монгол Улсын ГХОГХА-ийн гаргасан мэдээгээр Япон, Өмнөд Солонгосын дараа 5-р байранд оржээ.

АНУ-ын Засгийн газар Монгол дахь АНУ-ын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга замуудыг хайж байна. 2004 онд АНУ-ын Далайн чанад дахь хувийн хөрөнгө оруулалтын корпорац буюу ОПИК Монгол Улсад хөрөнгө оруулах сонирхолтой Америкийн компаниудыг дэмжиж 1 сая долларын зээлийн шугамыг нээсэн байна. Одоо Монголд байгаа АНУ-ын 3 компани ОПИК-аас санхүүжилт авах хүсэлтээ гаргаад байна. АНУ-ын Худалдаа, хөгжлийн агентлаг өнгөрсөн жил хэд хэдэн багийг Монголд ирүүлж, АНУ-аас хөрөнгө оруулалт хийх боломжийг судалсан. Монголын ИНЕГ-т агаарын хөдөлгөөний хяналтын шинэ системийг тавих олон улсын тендерт бэлдэхэд нь туслах зорилгоор нарийвчилсан үнэлгээ хийх ажлыг ХХА санхүүжүүлсэн. Энэ тендерт оролцсон Америкийн нэг компани ялсан билээ.

Гэхдээ Америкийн болон барууны компаниуд Монгол дахь бизнес, хөрөнгө оруулалтын орчинг хүндрэлтэй гэж үздэг. Монгол Улсад бизнес хийж буй Америк, Канадын гол гол компаниудыг төлөөлдөг ХАМБЗ-тэй хамтран АНУ-ын ЗГ болон манай хөрөнгө оруулагч нарын санаа зовниж буй нилээд тооны асуудлуудыг Монголын талд тавьсан юм. Тэдгээрийн дотор Монгол улсад шийдвэр гаргалтын түвшинд ил тод байдлыг нэмэгдүүлэх, оюуны өмчийг хамгаалах, гаалийн дүрэм журмыг сайжруулах, төрийн өмчит аж ахуйн нэгжүүд, ялангуяа эрчим хүч, цахилгаан холбоо, иргэний нисэх зэрэг гол гол салбаруудын хувьчлалыг үргэлжлүүлэх, зах зээлд төр засгийн оролцоог багасгах, татварын өргөн хүрээтэй шинэтгэл хийх шаардлага байгааг тэмдэглэсэн.

Ил тод байдал: Монгол улсад хууль тогтоомж, захиргааны журмыг боловсруулж, хэрэгжүүлэх үйл явц нь ил тод биш, урьдчилан таамаглах боломжгүй байдаг. Энэ нь төр засагт итгэх итгэлийг багасгаж, дотоод гадаадын хөрөнгө оруулагчдын аль алинд “эрсдэл” үүсгэж байна.

Өнгөрсөн жил ХАМБЗ, ЭСЯ хамтран эрх зүйн зохицуулалтын хүрээнд ил тод байдлыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулагч нар болон бусад хувьцаа эзэмшигчдийн дуу хоолойг сонсох шаардлагыг Ерөнхий сайд, түүний Засгийн газарт хүргэсэн билээ. Ялангуяа засгийн газраас санаачлан өргөн барьсан, хүлээгдэж байгаа хууль тогтоомжийн бүх төслүүдийн талаархи мэдээллийг олон түмэнд цаг алдалгүй түгээхэд “Нээлттэй засаг” вэбсайтыг ашиглах санааг бид хамтдаа дэвшүүлсэн. Иргэд, хөрөнгө оруулагчид урьдчилан таамаглаж болохуйц хууль, эрх зүйн зохицуулалтыг хүсч байна. Мөн нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөж буй тохиолдолд тэдэнд мэдэгдэж, тэдэнтэй зөвлөлдөж байхыг хүсч байна.

“Нээлттэй засаг” вэбсайт хуулиудад оруулахаар хэлэлцэгдэж буй өөрчлөлтүүдийг бүгдийг нь биш ч заримыг нь олон нийтэд мэдээлэх талаар амжилттай ажиллаж байна. Энэ үйл явцыг цааш нь гүнзгийрүүлж, шинэ хуулиуд болон нэмэлт өөрчлөлт оруулах саналын 70 орчим хувь нь яамдаас гардаг учир тэдний санаачилж буй хуулийн бүх төслүүдийг хамруулах хэрэгтэй байна.

Авилгал. Ил тод, олон нийтэд нээлттэй байх нь авилгалыг бууруулахад маш их нэмэр тустай. Саяхан АНУ-ын ОУХА-ийн гэрээний дагуу бие даасан консалтингийн фирмийн явуулсан судалгаа “...Монгол улсад “жижиг сажиг” буюу захиргааны түвшинд ч, “их хэмжээний” буюу элит түвшинд ч авилгалын боломж улам өссөөр байна. Авилгалын энэ хоёр хэлбэрийн аль аль нь Монголчуудын санааг зовоох ёстой асуудал хэдий ч “их хэмжээний” авилгалыг нилээд ноцтойд авч үзэх ёстой юм. Учир нь ийм төрлийн авилгал эдийн засаг, улс төрийн эрх мэдэлтнүүдийн хоорондох холбоог нягтруулж, бусад хуучин социалист орнуудад тохиолдсон шиг ардчилал, хөгжил цэцэглэлтэнд муу нөлөө үзүүлээд зогсохгүй бүр ардчиллын замаас ухрахад ч хүргэх аюултай” гэж дүгнэжээ. (Монгол улс дахь авилгалын байдалд хийсэн үнэлгээ, 2005 оны 8-р сар, АНУ-ын ОУХА-ийн DFD-1-00-03-00139-00 тоот гэрээ)

НҮБ-ын Авилгалын эсрэг конвенцид гарын үсэг зурж, соёрхон батлах талаар Монгол улс үүрэг хүлээж буйг манай Засгийн газар сайшаан дэмжиж байна. Монгол улс уг конвенцид энэ оны 4-р сард гарын үсэн зурсан нь эхний зөв алхам боллоо. Гэхдээ Конвенцийг соёрхон баталж, түүний заалтуудыг хэрэгжүүлэхийн тулд дотоодын хууль тогтоомждоо нэмэлт өөрчлөлт оруулах илүү хэцүү зорилт өмнө нь байна. Еранхийлөгч Буш хэлсэн үгэндээ УИХ авилгалын эсрэг чангахан бөгөөд үр дүнтэй хууль баталж гаргах асуудлыг нэн тэргүүнд авч үзэх ёстой гэж тэмдэглэсэн.

Энэхүү конвенц нь янз бүрийн эх үүсвэрээс хуримтлуулсан туршлагыг нэгтгэн боловсруулсан нарийвчилсан төлөвлөгөөг түүнд нэгдэн орсон улс орнуудад өгч, тэр нь тухайн улс орнуудын хууль тогтоомжид тусгалаа олж байхаар хийгдсэн байна. Энэ нь ялангуяа өөрийн орны болон гадаадын төрийн албан хаагчдын үйлдсэн хээл хахуулийн хэрэг болоод эд хөрөнгө шамшигдуулах, мөнгө угаах зэрэг авилгатай холбоотой бусад гэмт хэргийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагыг төр засгуудад тавьдаг. Төрийн албан хаагчдын шударга чанарыг хөхүүлэн дэмжиж, авилгын эсрэг тэмцэлд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх зэргээр авилгаас урьдчилан сэргийлэх хэд хэдэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг мөн шаарддаг.

Ялангуяа “сонирхлын зөрчил” буюу мөнгө, хээл хахууль авсан үгүйгээс үл шалтгаалан хувийн болон гэр бүлийн, эсвэл найз нөхдийн эрх ашгийн тулд улс төр, төр засгийн алба, албан тушаалаа урвуулан

ашигласан үйлдлийг зөв тодорхойлж, түүнээс сэргийлэх арга хэмжээ авч, шийтгэл оногдуулахыг төр засгуудаас шаарддаг юм. Би Монгол улсын хууль тогтоомжид “сонирхлын зөрчил”-ийн талаар тусгасан, эсвэл тодорхойлсон зүйл, заалт одоогоор байхгүй байна гэсэн ойлголттой байгаа. Ёс зүйн тухай хууль “сонирхлын зөрчил”-өөс сэргийлэх, ийм үйлдэлд хариуцлага хүлээлгэхэд анхаарлаа хандуулснаар элит болон захиргааны түвшний авилгалтай тэмцэх чиглэлд урагшаа том алхам хийх юм.

Оюуны өмчийн хамгаалал. Оюуны өмчийг хамгаалах асуудлыг хүчтэй тавьж чадах юм бол Монгол улс оюуны өмчийн хувьд бүс нутгийн бусад зах зээлүүдээс ялгарч харагдах маш сайхан боломж бий. Оюуны өмчийг хамгаалах асуудлыг ЭСЯ маш чухалд үзэж, Монгол улсын Оюуны өмчийн газартай сайн харилцаа тогтоож чадсан билээ. Эдгээр хүчин чармайлтын дотор АНУ-ын Патент, барааны тэмдгийн албатай хамтран энд болон Вашингтонд явуулж буй сургалтууд, мөн гааль, цагдаа, бизнесийн байгууллагуудтай хамтран явуулж буй бусад үйл ажиллагаанууд багтаж байна.

Мөнгө, санхүү, банкны бодлого болон мөнгө угаахтай тэмцэх бодлого. Хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулах тухай шийдвэр гаргахдаа мөнгө, санхүү, банкны орчин эрүүл эсэхийг анхааралтай хардаг. Энэ ч утгаараа АНУ-ын Засгийн газар, түүний дотор Сангийн яам, Төрийн департамент, Мянганы сорилтын корпораци нь Олон улсын валютын сангийн Монгол дахь хөтөлбөр 2005 оны 7-р сарын эцсээр дуусгавар болсныг анхааралдаа авсан билээ. Дараа нь өөр хөтөлбөр хэрэгжих эсэх нь одоо тодорхойгүй байна.

АНУ-ын Засгийн газар ОУВС болон түүний хөтөлбөрүүдийг дэмжиж байдаг бөгөөд ОУВС-аас өгсөн зөвлөмжүүд, ялангуяа Монголбанкны менежмент, Монголбанк, Сангийн яамны харилцаа, тус банкныг УИХ-аас хянах асуудал, мөн тус банкнаас арилжааны банкуудад хийх зохицуулалт зэрэгт байгаа асуудал, зөрчил дутагдлыг засах тухай зөвлөмжүүдийг Монгол улс хэрэгжүүлнэ гэж найдаж байна.

Ялангуяа мөнгө, санхүүгийн салбар дахь сайн засаглал, ил тод байдал, төр засгийн хариуцлага нь эдийн засгийн тогтвортой хөгжилд хүрэх, ардчиллын үйл явцыг үргэлжлүүлэхэд чухал ач холбогдолтой. Эдгээр зүйл байхгүй бол гадаадын тусламжийн үр нөлөө хязгаарлагдмал болж,

Монгол улсын эдийн засаг, нийгмийн хөгжил цэцэглэлтэнд тус нэмэр болж чадах гадаадын хөрөнгө оруулалтыг татахад хэцүү болно.

Цаашид юу хийх вэ?

Өнгөрсөн 11-р сарын 21-нд Ерөнхийлөгч Бушийн Монголд хийсэн айлчлалаас мэдэгдэхүйц 3 үр дүнг харж болохоор байна.

Эхнийх нь, Ерөнхийлөгч Буш болон хатагтай Буш, тэднийг дагалдан ирсэн хүмүүс (түүний дотор Төрийн нарийн бичгийн дарга Кондолиза Райс) төр засгийн өндөрлөгүүд болоод жирийн иргэн Монголчуудтай нүүр тулан ярилцаж, тэдэнд тулгарч буй бэрхшээл зовлонг өөрсдөөс нь шууд сонсож мэдэх боломж олдсон. Хувийн харилцаа, Монголын дүр зураг зэрэг нь удаан хадгалагдаж үлдэх зүйлс юм. Энэ айлчлал нь Монгол улс, Монголчуудын тухай Америкчууд илүү сайн ойлголт авч, тэдэнд талархалтай хандах явдлыг нэмэгдүүлж байна.

Ерөнхийлөгч Буш, хатагтай Буш нар Монголд айлчлахдаа сэтгэл нь маш их хөдөлж байсан. Тэд Монголын тухай болон Монголчуудад тулгарч буй асуудал, бэрхшээлийн талаар олон асуулт тавьж, нилээд их зүйлийг мэдэж авсан. Жишээ нь, малчин айлд зочлохдоо дундаж малчин Монгол айлын амьдрал ямархуу байдаг, тэд яаж амьдралаа авч явдаг, эдийн засаг, цаг уурын ямар бэрхшээлүүд тохиолддог, хүүхэд багачуудынхаа боловсролд яаж анхаардаг, эмнэлгийн үйлчилгээ авах болвол яаж авдаг зэрэг олон зүйлийг мэдэж авсан. Монголчуудын 40 орчим хувь нь нүүдлийн мал аж ахуй эрхэлсээр байгаа болохоор энэ нь их ач холбогдолтой уулзалт байлаа.

Түүнээс гадна, хатагтай Буш “Улс төр, засаглал дахь эмэгтэйчүүдийн түншлэл” холбооны эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй уулзсан юм. Энэ нь улс төр, засаглалд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр АНУ-ын ОУХА болон Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэнгээр дамжуулан АНУ-ын Засгийн газраас туслалцаа авсан эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд ч бас бий)-ийн холбоо юм. Уг уулзалтад оролцсон эмэгтэйчүүд УИХ-д суудалтай улс төрийн намууд болон сонгуулийн шинэчлэлийн үйл ажиллагаанд оролцож буй нэр хүнд бүхий ТББ-уудыг төлөөлж байлаа. Тэдний яриа голчлон улс төр, засаглалын түвшинд эмэгтэйчүүдэд тулгардаг саад бэрхшээлүүд болоод тэдгээрийг яаж арилгах вэ гэдэгт чиглэгдэж байв. Хатагтай Буш

өөрөө номын санч мэргэжилтэй учир боловсрол, залуучуудын асуудлаар асуулт тавьж байв.

Хоёрдугаарт, уг айлчлал, ялангуяа Ерөнхийлөгч Бушийн хэлсэн үг Америкийн төдийгүй олон улсын хэвлэл мэдээллийнхний анхаарлыг Монгол руу хандуулсан. Үүний үр дүнд зөвхөн Америкт төдийгүй дэлхийн өнцөг булан бүрт илүү олон хүн Монгол Улсын тухай, эрх чөлөө, ардчиллын үйл хэрэгт оруулж буй хувь нэмрийнх нь талаар сонслоо. Энэ нь олон улсын тавцан дахь Монгол улсын нэр хүнд, имижийг нэмэгдүүлэхэд тус нэмэр болж байгаа юм.

Гуравдугаарт, Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдтай Ерөнхийлөгч Бушийн хийсэн албан уулзалтууд дээр хоёр талын харилцааны тодорхой асуудлууд, тухайлбал худалдаа, хөрөнгө оруулалт, сургалтын тэтгэлэг, ардчиллыг бэхжүүлэх, олон улсын энхийг сахиулах ажиллагаа зэрэг асуудлуудыг хэлэлцсэн. Уулзалтын дараа гаргасан Хамтарсан мэдэгдэлд дурьдсанаар бид “иж бүрэн түншлэлийн харилцаа”-гаа өргөжүүлэн гүнзгийрүүлэх зарим “удирдах зарчмууд”-ыг хэлэлцэж, тохиролцох юм.

Тэгэхээр ирэх жил надад хийх ажил хэр их байгааг та бүхэн харж байгаа байх.

Анхаарал тавьж, хүлээцтэй сонссонд баярлалаа. Та бүхний сонирхсон асуултуудад хариулахад таатай байх болно.